



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/513

Булган сум

Зөвлөхтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД 81-16-20, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолын 4 дугаар хавсралтын 2.15 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын баяр наадам зохион байгуулах талбайн байршлын зохион байгуулалтын болон харагдах байдлын экстерьер 3d зураглал боловсруулах ажлыг 10,00,000 (арван сая) төгрөгөөр Монгол Улсын мэргэшсэн архитектор Ц.Мөнхтулгатай гэрээ шууд байгуулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг Монгол Улсын мэргэшсэн архитектор (Ц.Мөнхтулга)-т үүрэг болгосугай.

3. Дээрх зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн бөгөөд аймгийн Ерөнхий архитектор (М.Цэрэнчимэд)-т даалгасугай.

4. Дээрх ажлын санхүүжилтийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



6324010876